
МЭДЭЭ · 2020 оны 4-р сарын 14

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ТЭНСЭЖ ХЯНАН ХАРГАЛЗАХ, ТЭНСЭЖ ХЯНАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ТУХАЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2020 оны I дүгээр улирлын дугаарт нийтлэгдсэн Баян-Өлгий аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор Т.Батсүхийн **"Эрүүгийн хууль дахь тэнсэж хянан харгалзах, тэнсэж хянан хүмүүжүүлэх тухай зохицуулалтыг боловсронгуй болгох нь"** судалгааны тайланг хүргэж байна.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ТЭНСЭЖ ХЯНАН ХАРГАЛЗАХ, ТЭНСЭЖ ХЯНАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ТУХАЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ



Баян-Өлгий аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Т.Батсүх

ТҮЛХҮҮР ҮГС

Тэнсэх, ял оногдуулахгүйгээр тэнсэх, тэнсэж хянан хүмүүжүүлэх, ял хойшлуулах, албадлагын арга хэмжээ, хорих ял оногдуулах журам

ТОВЧЛОЛ

Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах болсон олон хэрэгцээ шаардлага байсны нэг нь хуулийн техник, нэр томьёоны оноолт хэвшээгүй асуудал[1] байсан боловч шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6, 7, 8 дугаар бүлэгт заасан эрүүгийн хариуцлагын төрөл болох тэнсэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой ойлголт, нэр томьёоны оноолтод шинэчлэл хийгдээгүй, дээрх бүлэг хоорондын уялдаа холбоо илтэд зөрчилтэй байгаа нь энэхүү өгүүллийг бичих гол учиг болов.

Эрүүгийн хуулийг шинэчлэн баталснаар өмнөх хуулийн /2002 оны/ алдаа дутагдлыг засаж, хуулийн техник, нэр томьёог зөв оноож боловсронгуй болгох талаар олон ахиц гарсан боловч зарим асуудлын хувьд тухайлбал ял оногдуулах, чөлөөлөхөд хэрэглэдэг журмуудын /тэнсэх, ял хойшлуулах, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх г.м/ агуулга, хууль зүйн үр дагаврыг оновчтой тодорхойлж, зохих бүлэг, зүйл, заалтад нь багтаан тогтоож чадсан эсэх нь эргэлзээтэй, хууль хэрэглээний маргаан дагуулсаар байна.

Нэг. УДИРТГАЛ

Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталснаас хойш дөрвөн жил, хүчин төгөлдөр болж дагаж мөрдсөнөөс хойш хоёр жил хагасын нүүр үзэж байна.

Дагаж мөрдөх буюу хүчин төгөлдөр болж үйлчилж эхлэхээсээ өмнө нэмэлт өөрчлөлт орсон «нэн онцлог” түүхтэй эрүүгийн хууль боллоо. Чухам л “мордохын хазгай” энэ хуулийг хэрэглэж эхэлснээс хойш зөрчил хийдэл ихтэй, ойлгомжгүй эргэлзээтэй заалт олон байгаа нь хэрэглэхэд бэрхшээл үүсгэсээр байна.

Үе үеийн Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага нь эрүүгийн хариуцлагатай /ялын төрөл, ял оногдуулах, ялаас чөлөөлөх, хөнгөрүүлэх, хүндрүүлэх, тэнсэх г.м/ холбогдсон байдаг. Энэ нь Эрүүгийн хуулийн “гэмт хэрэг ба ял” хэмээх өөрийн онцлог зохицуулалттай шууд холбоотой. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хорих ялыг биечлэн эдлүүлэхийг багасгах, гэм буруутай хүний гэм бурууг өөрөөр нь ухамсарлуулан хүмүүжүүлэх, цээрлүүлэх, хохирлыг нөхөн төлүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхэд чиглэсэн эрүүгийн ялын бодлогын шинэлэг чиг хандлагыг /гэм бурууг хүлээсэн хохирлоо төлсөн бол ял оногдуулахгүй байх, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ г.м/ оруулж ирсэн нь дэвшилтэй болсон.

Эрүүгийн эрх зүйн онолын тэнсэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах гэсэн эрүүгийн хариуцлагын

[1] Х.Эрдэм-Ундрах Эрүүгийн хариуцлага ба ялын зорилго. Эрх зүй сэтгүүл. 2019 он, Тусгай дугаар, 91 дэх тал

уламжлалт ойлголтууд үе үеийн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тусгалаа олж, ямар нэгэн салаа утгагүй, ойлгомжтой байдлаар томьёологдож зохих хэсэг зүйл заалтад тусгагдаж ирсэн байдаг.

Дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн чиг хандлагад нийцүүлэн хорих ялыг багасгаж хүнийг нийтийн дунд хүмүүжүүлэх, цээрлүүлэх байдлаар ялыг нь эдлүүлэх буюу ялтан хүний ажиллаж амьдрах, сурч боловсрох эрхийг хангахад чиглэсэн ялын уян хатан, үр нөлөөтэй байх бодлого, зорилгод нийцүүлэн хорих ял оногдуулж тэнсэх, оногдуулахгүйгээр тэнсэх, насанд хүрээгүй хүнийг тэнсэж хянан хүмүүжүүлэх, ял хойшлуулах, ялаас чөлөөлөх зэрэг олон арга хэмжээг хэрэглэдэг. Одоогийн Эрүүгийн хуулийг анхлан боловсруулсан төсөлд[2] хорих ялыг тэнсэж хянан харгалзах, тэнсэж хянан хүмүүжүүлэх талаар тодорхой тусгасан байх боловч 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулан батлах үед болон 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулахдаа анхны уг үзэл баримтлал нэлээдгүй өөрчлөгдсөн бол 2018 оны 6 дугаар сард оруулсан өөрчлөлтөөр улам ээдрээтэй болгосон байна. Хуулийн тогтвортой үйлчлэх зарчим алдагдсанаас Эрүүгийн хуулийн 6, 7, 8 дугаар бүлэгт заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх, чөлөөлөх үндэслэл журам, тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх, өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх журмын талаарх зарим зүйл заалтууд давхацсан, хоорондоо зөрчилдсөн, хэрэглэхэд эргэлзээтэй, өмнөх хуулиа төсөөтэй хэрэглэхэд хүргэж болзошгүй байдалтай байна.

Чухам иймээс шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нарын дунд маргаан үүсгэж түүнийг шийдвэрлэх талаар санал бодлоо илэрхийлж гарц гаргалгаа хайсаар[3] байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6, 7, 8 дугаар бүлэгт заасан зарим зохицуулалтууд нь практикийн төдийгүй онолын олон маргааныг дагуулж байх тул ял оногдуулах, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэглэх талаарх эрүүгийн эрх зүйн онолын суурь ойлголтын уламжлал, шинэчлэлийн хандлагад нийцүүлэн санал бодлоо хуваалцаж байна.

Хоёр. Ялыг тэнсэх, ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, тэнсэж хянан хүмүүжүүлэхийн ойлголт ба онцлог

Оногдуулсан хорих ялыг тэнсэх, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, тэнсэж хянан хүмүүжүүлэх нь хэлбэрийн хувьд оногдуулсан ялыг биеэр эдлүүлэхгүй тодорхой хугацаагаар итгэл үзүүлж, тэнсэн туршиж байгаа хууль зүйн үр дагавар, ач холбогдлын хувьд бараг ижил зохицуулалт. Ялгаатай тал нь ял шийтгүүлж буй субъектийн төрөл, онцлогтой холбоотой байдаг.

Эдгээр нь үйлдсэн гэмт хэргийн шинж байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний субъектив онцлог байдалтай холбоотойгоор хорих ял оногдуулахад хэрэглэдэг тусгай журмууд юм.

Тэнсэх гэдэг нь хүнд гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүй түдгэлзэж[4] итгэл хүлээлгэж, нөгөө талаар дахин гэмт үйлдэл гаргахгүй байх өндөр хариуцлага үүрүүлж буй ял оногдуулахад хэрэглэдэг өвөрмөц журам мөн. Ингэж итгэл хүлээлгэж, хариуцлага үүрүүлэхдээ тухайн ялтан хүнийг хууль сахиулах байгууллагын хяналтад байлгаж хэрэгжүүлдэг.

[2] Гэмт хэргийн тухай хуулийн төсөл. Уб., 2014 он.

[3] Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь. Онол практикийн хэлэлцүүлэг. Уб., 2019 он 18-19 дэх тал, Г. Ганбаатар. Шүүх эрх мэдэл сэтгүүл. Уб., 2018 он. №3, 120-121 дэх тал, Б.Ариунжаргал. Тэнсэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт. Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2019 он дугаар 2.102-108, П. Эрдэнэбаатар. Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах ажиллагаа. Хууль дээдлэх ёс сэтгүүл. Уб., 2019 он, №2 , 78 дахь тал

[4] Орчин цагийн монгол улсын эрүүгийн хуулийн анхдагч буюу 1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн 31-р зүйлд “ялыг түдгэлзүүлэн тэнсэх” гэж томьёолж мөн хуулийн 8-р зүйлд оноосон ялыг түдгэлзүүлэх хугацаа 3-5 жил байхаар тогтоосон байна.

Хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүй 2 жил хүртэлх хугацаагаар хойшлуулдаг бол хүнд биш гэмт хэрэг[5] үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж хянан хүмүүжүүлдэг онцлогтой.

Монгол Улсын орчин цагийн Эрүүгийн хуулийн хөгжлийн түүхэнд 1926, 1929, 1934, 1942, 1961, 1986, 2002 онд нийт 7 удаа шинэчлэн баталсан Эрүүгийн хуулиудад "тэнсэх"-дээ хорих ял оногдуулж, уг оногдуулсан ялыг биеэр эдлүүлэхгүй ялтныг цагдаагийн байгууллагын хяналтад харгалздаг байсан.

1926 оны Шүүх цаазын бичигт ялыг хөнгөрүүлэх нотлох баримттай гэмт хэрэг үйлдсэн бол 1-5 жилийн хугацаатайгаар түдгэлзүүлэн тэнсэх гэж тодорхойлсон бол 1929 оны Шүүх цаазын бичигт хөнгөн гэмт хэрэг анх удаа ядуу зүдүү, боловсролгүй мэдлэггүйгээсээ болж гэмт хэрэг үйлдсэн бол хошууны захиргаанд 1 жил хүртэлх хугацаагаар сар бүр хянуулж байхаар тогтоосон нь орчин цагийн Эрүүгийн хуульд дахь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж хянан харгалзах журамтай дүйцдэг. 1934 оны Шүүх цаазын бичгийн 38 дугаар зүйлд[6] "....тогтоосон ял эдлүүлэхийг түдгэлзэж, тэнсэхээр тогтоох эрхтэй болно. Хянан тэнсэхээр шийтгэх гэдэг нь ..... тогтоосон хянан харгалзах хугацааны дотор.... хуучин хэргээс хөнгөн бус шинэ гэмт хэрэг үйлдэхгүй бол таслан шийтгэсэн тогтоолыг гүйцэтгэхгүй гэж тогтоосныг хэлнэ" гэж анх удаа "тэнсэх" ойлголтыг тодорхойлсон байна. Эндээс ял оногдуулахад хэрэглэдэг нэг өвөрмөц журам болох тэнсэж хянан харгалзахын мөн чанарыг төвөггүй ойлгож болно. Өөрөөр хэлбэл тэнсэж хянан[7] харгалзсан хугацаанд итгэл найдварыг алдаж гэмт хэрэг үйлдвэл шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулахаар заасан нь "тэнсэх"-ийн хууль зүйн агуулга, мөн чанарыг илэрхийлнэ.[8]

Тэнсэх гэдэг үгийн агуулгыг ухаж үзвэл тэнсэж турших-ажиглан харах, сорьж үзэх, суллан тавьж тэнсэх- шоронд хорилгүй хийсэн хэрэгт нь тохирсон хугацаагаар сорин үзэх гэж тайлбарласан байна.[9] Ялыг тэнсэх, ял оногдуулахгүйгээр тэнсэх нь эрүүгийн хариуцлагын төрөл гэж эрх зүйн онолын түвшинд эрдэмтэн судлаачид тодорхойлж ирсэн.[10] Түүнчлэн тэнсэх гэдэг нь хорих ял эдлүүлэх онцгой журам,[11] эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх онцгой хэлбэр, ял эдлүүлэх хэлбэр[12] гэх зэргээр олон талаас нь тайлбарлаж, тодорхойлжээ.

Дээр дурдсан үе үеийн Эрүүгийн хуулийн зохицуулалтаас[13] үзэхэд "тэнсэх" нь хорих болон албадан ажил хийлгэх ял / хуучнаар/ оногдуулахад шүүхээс хэрэглэдэг онцлог журам болох нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл "тэнсэх" нь эрүүгийн хариуцлагын төрөл биш, бие даасан арга хэмжээ биш[14] харин хорих ял оногдуулахад шүүхээс гаргах шийдвэр буюу ял оногдуулах өвөрмөц журам гэдэгтэй санал нэгдэж байна. Тэнсэхийн мөн чанар, хууль зүйн ач холбогдол нь оногдуулсан

[5] Өмнөх үе үеийн Эрүүгийн хуульд хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэдэг байсан. 2015 оны Эрүүгийн хуулиар 2017.07.01-нээс 2018.06.27-ны хүртэл хугацаанд "хөнгөн" гэмт хэрэгт, үүнээс хойш хүнд гэмт хэрэгт хэрэглэж болохоор зохицуулсан юм. Гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилснаар гэмт хэргийн хор аюулын шинж, хувийн байдлыг харгалзан ялгамжтайгаар ял оногдуулах боломж хязгаарлагдсан. Өмнөх эрүүгийн хуульд оногдуулах ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг ангилдаг байсан уламжлалыг зөв оновчтой тодорхойлж чадаагүйгээс гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж үгүйсгэгдэхэд хүргэсэн. Хүнийг санаатай алсан ч хүнд гэмт хэрэг, айлаас аяга таваг хулгайлсан ч хүнд гэмт хэрэг болсон.

[6] Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/, Уб., 2011 он, 353 тал.

[7] 1986 онд баталсан БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлд ...хүлээлгэсэн итгэл, найдварыг биелүүлснээ... харуулсан бол... гэжээ.

[8] Хууль дээдлэх ёс сэтгүүл цуврал 58, 87 дахь тал.

[9] Монгол хэлний тайлбар толь аплекейшин

[10] Г.Совд БНМАУ-ын Эрүүгийн уулийн дэлгэрэнгүй тайлбар, Уб., 1989 он, 58 дахь тал.

[11] С.Нарангэрэл Монгол Улсын Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги, Уб.,1999 он 327 дахь тал.

[12] Монгол Улсын Дээд Шүүхийн 1998 оны 315 дугаар тогтоол МУ-ын Дээд Шүүхийн эмхэтгэл, Уб., 1999 он, 197 дахь тал.

[13] 1926 оны Шүүх цаазын бичгийн 30-р зүйл, 1929 оны Шүүх цаазын бичгийн 15-р зүйл, 1961 оны Эрүүгийн хуулийн 33-р зүйл, 1986 оны Эрүүгийн хуулийн 40-р зүйл, 2002 оны Эрүүгийн хуулийн 61-р зүйл, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн уламжлал /1911-2009 он/ Уб., 2011 он.

[14] Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль сургагч багш нарт зориулсан гарын авлага. Уб., 2017 он, 71 дэх тал.

эсхүл оногдуулах байсан хорих ялыг биеэр эдлүүлэхгүй түдгэлзэж гэм бурууг нь өөрөөр нь ухамсарлуулах, өөрөө өөрийгөө хянаж ялаа эдлэх,[15] дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлж өөрт нь итгэл найдвар хүлээлгэж байгаад оршино. Ял тэнсэхийн нэг өвөрмөц шинж нь гэмт хэрэг үйлдсэн хүн учруулсан хохирлоо нөхөн төлсөн[16] байх, нөхөн төлөхөө бодитой илэрхийлсэн байх[17] явдал юм.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах журмыг гэмт хэрэг анх удаа үйлдсэн[18] нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүхээс үзсэн "онцгой субъект"-үүдэд[19] хэрэглэдэг журам юм.

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулахад хэрэглэдэг нэг өвөрмөц журам болох хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний талаар анх 1934 оны Шүүх цаазын бичигт "...16-18 хүртэл насны идэрчүүдийн хэргийг таслахдаа шүүн таслах газраас эдгээр идэрчүүдэд ял оногдуулахыг тусгүй гэж үзвэл" гэж тусгаснаас хойш 1961 оны Эрүүгийн хуульд "албадан хүмүүжүүлэх чанарын арга хэмжээ" гэж, 1986 оны Эрүүгийн хуульд "хүмүүжлийн чанартай албадлын арга хэмжээ" гэж тус тус нэрлэж хэрэглэсэн. Энэ арга хэмжээг 1995 оны Эрүүгийн хуулиас хасаж,[20] 2002 оны Эрүүгийн хуульд дахин оруулж ирсэн байна.

Гурав. Шинэ Эрүүгийн хууль дахь тэнсэх, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх журмыг зохицуулахад гарсан зөрчил, давхцал, түүнийг боловсронгуй болгох нь

Манай улсын 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд "тэнсэх"-ийг ял оногдуулах, ялаас чөлөөлөх үндэслэл журам гэсэн бүлэгт оруулан тогтоож байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар тусдаа тэнсэх албадлагын арга хэмжээ гэсэн бүлэгт багтаан зохицуулсан. Эндээс "тэнсэх" нь эрүүгийн хариуцлагын төрөл үү эсхүл ял оногдуулахад хэрэглэдэг журам уу, тусдаа бие даасан арга хэмжээ юм уу гэдэг асуулт урган гарч байна. Эдгээр ойлголтуудыг зөв тодорхойлж чадаагүйгээс ял тэнсэх журмыг 2015 оны Эрүүгийн хуульд 6, 7 дугаар бүлэгт давхцуулан зохицуулсан нь хэрэглэхэд ойлгомжгүй байдал үүсгэжээ.

Шинэ Эрүүгийн хууль дахь шинэлэг зохицуулалт бол 6.7-р зүйлд заасан хорих ялыг хөнгөрүүлэх асуудал юм. Гол шинж нь "гэм бурууг хүлээн зөвшөөрсөн, учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол хорих ялыг хөнгөрүүлж болно. Харин уг 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, дахь хэсэгт "ялаас чөлөөлөх", "тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх" гэсэн диспозец бол "шинэлэг" бөгөөд туйлын утгагүй буруу зохицуулалт юм. Учир нь ялаас чөлөөлөх хэд хэдэн уламжлалт үндэслэл нөхцөлийг 6.12, 6.13, 6.14, 6.15 /шинээр/ дугаар зүйлээр зохицуулсан байгаа нөхцөлд 6.7 дугаар зүйлд давхар заах шаардлагагүй бөгөөд хэрэглэхэд ойлгомжгүй болгосон. Мөн уг зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэгт заасан "тэнсэх" нь мөн хуулийн 7.1 дүгээр зүйлийн "тэнсэх" үндсэн зохицуулалттай давхцаж зөрчилдөөн үүсгэж байна.[21] Гэмт хэргийн ангиллын хувьд ижил, тавьж буй болзол

[15] Улсын дээд шүүхийн 1998 оны 315 дугаар тогтоолд "...ял эдлүүлэх хэлбэр, мөн" гэсэн нь үүнтэй холбоотой, Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл. Уб., 1999 он, 197 дахь тал.

[16] Хохирол нөхөн төлсөн байх шаардлагыг 1986 оны Эрүүгийн хуулийн 40-р зүйлд тайлбарласан Улсын Дээд Шүүхийн 1998 оны 315 дугаар тогтоолд "...учруулсан хохирлоо төлөхөд санаачилга гаргаагүй" гэж дурдсан байдаг. Улмаар 2002 оны Эрүүгийн хуулийн 61-р зүйлд учруулсан хохирлоо нөхөн төлсөн байхыг, 2015 оны Эрүүгийн хуульд нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлсэн байх болзлыг тус тус тусгасан байна.

[17] Энэ нь шинэ Эрүүгийн хуулийн үзэл баримтлалын шинэчлэлийн нэг чухал хэсэг бөгөөд гэм бурууташ хүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн онцлог болзол билээ.

[18] 2002 оны Эрүүгийн хуульд хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ах, ганц бие эцэгт оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар зөвхөн хөнгөн гэмт хэрэг үйлдсэн бол энэ журмыг хэрэглэхээр зохицуулсан нь энэ төрлийн субъектүүдийн эрх зүйн байдлыг дордуулсан өмнөх дэвшилттэй зохицуулалтаас ухарсан алхам болжээ.

[19] Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Уб., 2002 он, 98 дахь тал.

[20] Төрийн мэдээлэл. 1996 он №02.

[21] Г.Ганбаатар Эрүүгийн хуулийн шинэчлэл "төсөл"-д зааснаар хязгаарлагдахгүй // Шүүх эрх мэдэл сэтгүүл. Уб., 2018 он №3, 120 дахь тал.

буюу гипотезийн хувьд ч адилхан байна. Шүүх ямар хэрэгт 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-ыг хэрэглэх, энэ нь 7.1 дүгээр зүйлээс юугаар ялгаатайг ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй болсон.[22]

Аймгуудаас авсан судалгаагаар шүүхүүд 2018 оны сүүл болон 2019 оны эхний улирлын байдлаар Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгчид оногдуулах ялыг тэнсэх шийдвэр гаргаж байснаа дараа нь 7.1 дүгээр зүйлд зааснаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж шийдсэн нийтлэг дүр төрх харагдаж байна. Жишээ нь Баян-Өлгий аймагт 2019 оны эхний 3 сард 5, Өмнө-Говь аймагт 7, Дундговь аймагт 3, Өвөрхангай аймагт 19 хүнд Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд зааснаар тусгай ангийн холбогдох зүйлд заасан ялыг тодорхой хугацаагаар тэнсэж шийдсэн бол Архангай, Дорнод аймагт уг зүйлээр тэнсэж шийдсэн тохиолдол байхгүй байна. Харин Говь-Алтай аймгийн шүүх 14 тогтоолоор тэнсэж шийдэхдээ 8 тохиолдолд нь Эрүүгийн хуулийн 6.7, 7.1 дүгээр зүйлийг давхар хэрэглэсэн[23] байна. Эндээс үзэхэд шүүхүүд дээрх хоёр зүйлийн аль зүйлийг хэрхэн хэрэглэх нь тодорхой бус байгаагаас янз бүрээр хэрэглэсэн төдийгүй ихэвчлэн 7.1 дүгээр зүйлээр тэнссэн буюу 6.7 дугаар зүйлийг хэрэглэхээс түдгэлзсэн, эргэлзсэн нь илт байна. Баян-Өлгий аймгийн шүүхийн 5 тогтоолыг үзэхэд тухайн зүйлд заасан хорих ялыг бүхэлд нь 1 жилийн хугацаагаар тэнссэн байна. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд заасан хорих ял нь 6 сараас 3 жил хүртэл байдаг ба уг хорих ялыг 1 жилийн хугацаагаар тэнссэн[24] байна.

Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийг тэнссэн хугацаа дууссан үед хэрэглэх эсэх, эсхүл тэнссэн хугацааны дотор хэрэглэх эсэх нь тодорхойгүй, хууль хэрэглээний эргэлзээ үүсгэж байна. Одоогийн практикт тэнссэн хугацаа дууссан бол уг хүнд ял оногдуулахгүй байх тухай прокурорын дүгнэлтийг шүүх хүлээн авахгүй байгаа.[25] Уламжлалт практикаар бол тэнссэн хугацаа дууссанаар хяналт тавьж байсан байгууллага хувийн хэргийг хааж прокурорт танилцуулснаар ялаас чөлөөлөгдсөнд тооцдог байсан. Нэгэнт тэнссэн, хугацаа дууссан бол[26] прокурор дүгнэлт бичиж шүүхэд шилжүүлэх, шүүх шийдвэр гаргаж, шат дараалсан их ажиллагаа, зардал, чирэгдэл[27] гаргах хэрэггүй юм. 2002 оны Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "тэнсэгдсэн ялтан шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй, засарч хүмүүжсэнээ харуулсан бол шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй" гэж хууль хэрэглээний эргэлзээ төрүүлэхгүй, тодорхой, ойлгомжтой заасан байсныг сэргээхэд л асуудал шийдэгдэнэ.

Албадлагын арга хэмжээний төрлийг 2002 оны Эрүүгийн хуулийн 64 дүгээр зүйлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэж үзэж тусгасан нь тухайн зохицуулалтынхаа агуулга, хэлбэрт нийцсэн байсан юм. Харин 2015 оны

[22] Манай улсын бүх бүсийг хамруулан 10 аймгийн Прокурорын газруудаас авсан судалгаагаар 2019 оны байдлаар гэмт хэрэг үйлдсэн 2448 хүнийг шийтгэх тогтоол гарсан ба Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.2, 1.2-т зааснаар тэнссэн тохиолдол 137, 7.1 дүгээр зүйлд зааснаар ялыг тэнссэн тохиолдол 269 байна. Говь-Алтай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн 6.7, 7.1 дүгээр зүйлийг давхар хэрэглэж хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн нь үүний тод жишээ юм.

23 Говь-Алтай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 27, 47, 49, 64, 67, 94, 97, 101 дүгээр шийтгэх тогтоол.

[24] Баян-өлгий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019-02-22-ны өдрийн 26 дугаар шийтгэх тогтоол.

[25] Баян-өлгий аймгийн Прокурорын газраас 2019 оны эхэнд уг зүйлээр 2 дүгнэлт шүүхэд хүргүүлэхэд 1 тохиолдолд ял оногдуулахаас чөлөөлсөн захирамж гаргаж, 1 дүгнэлтийг хэлэлцэх шаардлагагүй гэж буцаасан байна. Үүний дараа Улсын Ерөнхий прокурорын газраас чиглэл хүргүүлснээр 2019 онд уг асуудлаар прокурорын дүгнэлтийг шүүхэд хүргүүлэхээс зайлсхийсэн бөгөөд нэгэнт практик тогтсон байна.

[26] Эрүүгийн хуулийн 2015 оны анхны анхны найруулгаар энэхүү заалтыг "тэнсэх хугацаа дууссаны дараа тухайн хүнд ял оногдуулах эсэхийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ" гэсэн нь тодорхой байсан бол 2017 оны өөрчлөлтөөр ойлгомжгүй болгожээ. Төрийн мэдээлэл сэтгүүл №7. Уб., 2016 он.

[27] Г.Ганбаатар Шүүх эрх мэдэл сэтгүүл №3. Уб.,2018 он, 122 дахь тал.

Эрүүгийн хуулиар энэхүү арга хэмжээг 6, 7, 8 дугаар бүлэгт давхцуулан оруулснаар уламжлалт ойлголтоос хазайж, салаа утгатай зохицуулалт болсон.

1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуулиудад хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг 1/ 6 сараас 1 жил хүртэл хугацаа тогтоож засарч хүмүүжихийг даалгах, 2/ орлого олдог бол хохирлыг арилгах үүрэг хүлээлгэх, эцэг эх ойрын төрөл садангийн хүний хяналтад өгөх, хамт олон, байгууллага, иргэний хяналтад байлгахаар шилжүүлэх, эсхүл хүмүүжүүлэгч томилох зэрэг өөр өөр агуулгатай арга хэмжээ авахаар заасан байсан. Ийм учир энэ нь албадлагын "арга хэмжээ" байсан. Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлд албадлагын арга хэмжээний төрлийг 1) Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах, 2) эмнэлгийн чанартай, 3) хөрөнгө, орлого хураах гэсэн гурван төрлийн албадлагын арга хэмжээ байхаар маш тодорхой заасан. Харин мөн хуулийн 8.7-р зүйлд "хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ" гэсэн нэр томьёоны оноолт хэрэглэсэн боловч агуулга нь ял оногдуулахыг тэнсэж хянан хүмүүжүүлэхээр заасан байна. Энэ нь шүүх өсвөр насны хүнд ял оногдуулахдаа хэрэглэдэг журам бөгөөд албадлагын арга хэмжээ биш гэж ойлгогдож байна.

Өсвөр насны хүнд оногдуулах ялыг тэнсэж хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэхдээ дээр дурдсан албадлагын арга хэмжээнээс үүрэг хүлээлгэх, албадлагын арга хэмжээг хэрэглэнэ гэж Эрүүгийн хуулийн 8.7-р зүйлийн 2 дахь хэсэгт ямар нэгэн салаа утгагүй тодорхой заасан. Тэгэхээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл байсан өмнөх Эрүүгийн хуулийн уламжлалт ойлголтоос татгалзсан гэж үзэж байна. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ гэдэг нэр томьёоны оноолтыг хэрэглэснээр уг албадлагын арга хэмжээ дотор давхар үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авах мэтээр ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэж байна. Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд ялыг оногдуулах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд тодорхой хугацаагаар /3 жил хүртэлх/ тэнсэж хянан хүмүүжүүлж болохоор томьёолсон нь агуулгын хувьд оновчтой болсон. Өөрөөр хэлбэл албадлагын арга хэмжээ биш[28] учраас цаашид "хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ" гэдэг нэршлээр Эрүүгийн хуульд хэрэглэхгүй байх нь зүйтэй юм.

Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "...ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл... хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно." гэж заасан нь 8.7 дугаар зүйлд заасан ял оногдуулахгүйгээр тэнсэж хянан хүмүүжүүлэх журамтай агуулгын хувьд зөрчилдөж байна. Учир нь өсвөр насны хүнд авах албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан байх тул 8.7 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээ гэж байхгүй. Өөрөөр хэлбэл шинэ хуулиар хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ гэдэг тусдаа албадлагын арга хэмжээ байхгүй /7.2 дугаар зүйлд/ болсон. Хэрэв 8.7 дугаар зүйлд заасан тэнсэж хянан хүмүүжүүлэхийг албадлагын арга хэмжээ гэж үзвэл түүнийг ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж хэрэглэх ямар ч боломжгүй. Тэнсэж хянан хүмүүжүүлэх буюу ялыг эдлүүлэхгүй байгаа тохиолдолд ял дээр нэмж хэрэглэх ойлголт байж боломгүй юм. Тэгэхээр Эрүүгийн хуулийн 6.1-зүйлийн 3 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 8.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ" хэрэглэх гэсэн нь 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалттай давхацсан төдийгүй "Эрүүгийн

[28] Судлаач Б. Амаржаргал Тэнсэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт өгүүлэлдээ Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн зохицуулалтыг "Албадлагын арга хэмжээ биш" өсвөр насны хүнд хорих ял оногдуулахад хэрэглэдэг журам /тэнсэж байгаа/ талаас нь авч үзсэн нь ХЧАА нь тэнсэх ойлголтоос огт өөр арга хэмжээ гэдэг уламжлалт онолын хандлага өөрчлөгдөж байгааг харуулж байна. //Хууль дээдлэх ёс сэтгүүл №2, 2019 он, 103 дахь тал.

хариуцлага хүлээлгэх насны хязгаар”-ын талаарх зохицуулалтад оруулан өсвөр насны хүнд ял оногдуулахгүй тэнсэж хянан хүмүүжүүлэх асуудлыг заасан нь оновчгүй болжээ. Өөрөөр хэлбэл өсвөр насны хүнд ял оногдуулахгүй тэнсэж хүмүүжүүлэх нь ял оногдуулах үед хэрэглэдэг журам учир “насны хязгаар”-ын талаарх заалттай шууд хамааралтай бус.

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах журмыг хэрэглэхдээ өмнөх Эрүүгийн хуулийн 62 дугаар зүйлд гэмт хэргийн ангиллыг харгалзахгүй анх удаа гэмт хэрэг үйлдсэн бол хэрэглэдэг байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн бол хэрэглэхээр заажээ. Энэ нь хүүхдийн эрхийг илтэд дордуулсан заалт болсон. Гэтэл Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өсвөр насны хүнд хорих ял оногдуулах шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулахдаа хүнд гэмт хэрэг /дээд хэмжээ 8 жилээс доош/ үйлдвэл хэрэглэхээр 2018 оны 06 сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан нь 7.6 дугаар зүйлтэй зөрчилдөж байна.

Нөгөө талаар 8.6 дугаар зүйл нь хорих ял оногдуулсан тохиолдолд ялыг эдлүүлэхгүй хойшлуулах тухай Эрүүгийн хуулийн үндсэн ойлголт байтал 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр “...эсхүл.... хорих ял оногдуулахаар заагаагүй” гэдэг гипотез оруулсан нь нэн хариуцлагагүй, ялын бодлогын хувьд илт алдаатай заалт гэж үзэхэд хүргэж байна.

ДҮГНЭЛТ

Дээр дурдсанаас үзэхэд шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн 6, 7, 8 дугаар бүлгийн зохицуулалтад эрүүгийн эрх зүйн тогтсон онолоос гажсан, өмнөх эрүүгийн хуулийн дэвшилтэд бодлогоос ухарсан, ял шийтгүүлж буй хүний эрх зүйн байдлыг дордуулсан, хийдэл, зөрчилтэй, хууль хэрэглээний эргэлзээ үүсгэсэн зүйл заалт олон байна. Иймд дээрх зүйл, заалтад дурдсан хийдэл, давхардал, зөрчлийг эс арилгаваас хууль хэрэглээний мухардмал байдалд орох, өмнөх Эрүүгийн хуулийн зохицуулалтыг төсөөтэй хэрэглэхэд хүргэх зэрэг сөрөг үр дагавартай юм.

САНАЛ

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд оногдуулах ялыг хойшлуулах, ял хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, өсвөр насны хүнийг тэнсэж хянан хүмүүжүүлэх зэрэг онцлог журмуудыг 6, 7, 8 дугаар бүлэгт зөв байршуулж боловсронгуй болгох талаар дараах саналыг дэвшүүлж байна.

Нэг. Бүлэг хоорондын давхардсан эсхүл өөр бүлэгт оруулсан зөрчлийг арилгах талаар:

1. Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн 3 дахь заалтыг 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгтэй давхацсан тул хасах хэрэгтэй. Ингэснээр 6.2 дугаар зүйлийн “Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар” гэсэн зохицуулалт оновчтой болно.

2. Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйл буюу “тэнсэх” нь Эрүүгийн хорих ял оногдуулахад хэрэглэдэг журам учраас албадлагын арга хэмжээний бүлэгт биш 6 дугаар бүлэг дотор 6.11 дүгээр зүйл болгож оруулах,

3. Эрүүгийн хуулийн 7.6 дугаар зүйл нь хүнд гэмт хэрэг үйлдсэн “онцгой субъект”-д хорих ял оногдуулахдаа шүүхээс хэрэглэдэг өвөрмөц бие даасан журам учраас албадлагын арга хэмжээний бүлгээс сугалж авч 6 дугаар бүлэгт оруулах нь хууль хэрэглээг оновчтой, тодорхой болгоно.

Хоёр. Зүйл, заалтуудын давхардал зөрчлийг арилгах талаар:

1. Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь заалт нь 7.1 дүгээр зүйлтэй илт зөрчилтэй тул бүрмөсөн хасах хэрэгтэй. Ингэснээр ялаас чөлөөлөх, тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх журам өөр өөрийн байрандаа орж хууль хэрэглээний эргэлзээ арилна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3105